

НҮБ-ЫН ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРХИЙН КОМИССИЙН ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТРЫН ЗАГВАР ХУУЛЬ

(НҮБ-ЫН A/40/17 дугаарын баримт бичиг, хавсралт I болон A/61/17, хавсралт I)

(1985 оны 6 дугаар сарын 21-ний өдөр НҮБ-ЫН Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос батлан, 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан болно)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ¹

1. Энэ хуулийг олон улсын арилжааны² арбитрт тухайн улс болон бусад улсын хооронд байгуулсан аливаа хэлэлцээрийг баримтлах нөхцөлд хэрэглэнэ.

2. Энэ хуульд заасан журмыг хуулийн 8, 9, 17 дугаар зүйлийн “Ж” хэсэг, 17 дугаар зүйлийн “З” хэсэг, 17 дугаар зүйлийн “И” хэсэг, 35, 36 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа арбитр хэрэглэнэ.
/Энэ заалтыг 2006 оны 39 дүгээр чуулганаар НҮБ-ЫН Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос өөрчлөн найруулсан/

3. Арбитр дараахи нөхцөлд олон улсын болно.

Үүнд:

а/ Арбитрын хэлэлцээрийн талууд гэрээ байгуулах үед өөр өөр улсад байсан бол

б/ Талуудын харьяа байгууллагын орших улсаас өөр дараахи газарт талуудын харьяа байгууллага байгаа бол

Үүнд:

1. Арбитрын хэлэлцээрт тодорхойлсон арбитрын орших газар

2. Арилжааны харилцаанаас үүсэх үүргийн ихэнх хэсэг нь биелэгдэх ёстой газар, эсвэл маргааны зүйлтэй салшгүй холбоотой газар байгаа бол

в/ Талууд арбитрын хэлэлцээрээр маргааны зүйл нь нэгээс илүү улсад хамааралтай хэмээн тодорхой тохиролцсон бол

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар:

а/ талууд нэгээс илүү харьяа байгууллагатай бол арбитрын хэлэлцээрт илүү холбоотойг нь харьяа байгууллагад тооцно.

¹ Энэ хуулийн зүйлийн гарчиг зөвхөн зөвлөмж маягаар ашиглагдаж байгаа бөгөөд тайлбар хийх зорилготойгоор ашиглагдахгүй.

² “Арилжааны” гэдэг нэр томъёонд гэрээний буюу гэрээний бус харилцаанаас үүдэн гарсан бүхий л харилцааг хамарсан өргөн утгаар тайлбарлана. Арилжаа худалдааны шинжтэй харилцаа нь дараах харилцаа хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй: бараа үйлчилгээ нийлүүлэх, солилцох аливаа худалдааны хэлцэл; дистрибутерын гэрээ, худалдааны төлөөлөгч, агент; факторинг; лизинг; барилгын ажил гүйцэтгэх; зөвлөгөө өгөх; инженеринг; лиценз олгох; хөрөнгө оруулалт; санхүүжилт; банкны ажиллагаа; даатгал; концесс буюу хайгуулын гэрээ; хамтарсан үйлдвэр ба бизнесийн бусад хэлбэрийг үүсгэн байгуулах; агаар, усан зам, төмөр зам, хуурай замаар бараа, зорчигч тээвэрлэх.

б/ хэрэв талууд харьяа байгууллагагүй бол тэдний байнгын оршин суугаа газрыг тооцно.

5. Энэ хууль нь тодорхой маргааныг арбитрт шилжүүлж болохгүй эсвэл энэ хуулиас өөр журам тогтоосон маргааныг арбитр шилжүүлж болох тухай тухайн улсын аль ч хуулийн заалтыг өөрчлөхгүй.

2 дугаар зүйл. Тайлбар ба тодорхойлолт

Энэ хуулинд заасан:

а/ “Арбитр” гэдэгт байнгын ажиллагаа явуулдаг эсэхээс үл хамааран аливаа нэгэн арбитрыг ойлгоно.

б/ “Арбитрын бүрэлдэхүүн” гэдэгт ганц арбитрч буюу арбитрын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнийг ойлгоно.

в/ “Шүүх” гэж төрийн шүүхийн системийн алба, байгууллагыг хэлнэ.

г/ Энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд тодорхой асуудлаар талуудад шийдвэр гаргах боломж олгохоор заасан бол талууд ийм шийдвэр гаргахыг гуравдагч этгээд буюу өөр байгууллагад даалгаж болно.

д/ Хэрэв энэ хуульд талууд тохиролцсон буюу тохиролцож болох, эсвэл бусад ямар нэг хэлбэрээр талууд тохиролцож болохоор заасан байвал ийм тохиролцоо нь энэ хэлэлцээрт заасан аль ч арбитрын журамд хамаарна.

е/ Энэ хуулийн 25 дугаар зүйлийн “а” хэсэг ба 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “а”-д зааснаас бусад тохиолдолд нэхэмжлэл гэж заасан бол тэр нь сөрөг нэхэмжлэлд мөн адил хамаарах бөгөөд татгалзал гэж заасан бол тэр нь сөрөг нэхэмжлэлийн татгалзалд мөн адил хамаарна.

2 дугаар зүйлийн “А” хэсэг. Олон улсын эх сурвалж болон үндсэн зарчмууд /Энэ зүйлийг 2006 оны 39 дүгээр чуулганаар НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос нэмэлт оруулсан/

1. Энэ хуулинд тайлбар хийхдээ түүний олон улсын эх сурвалж болон хуулийг нэг мөр хэрэглэх, үүргээ шударгаар сахин биелүүлэх зэргийг харгалzan үзнэ.

2. Энэ хуулиар зохицуулж буй асуудал уг хуулиар тусгайлан заагаагүй бол түүнийг мөн хуулийн суурь болсон үндсэн зарчмуудад нийцүүлэн зохицуулна.

3 дугаар зүйл. Бичиг баримт хүлээн авах

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол:

а/ Аливаа бичиг баримтыг хүлээн авагч талд биеэр, эсхүл түүний харьяа байгууллагын байнгын оршин суугаа газарт буюу түүний шуудангийн хаягаар хүргүүлсэн бол уг бичиг баримтыг хүлээн авсанд тооцно. Хэрэв хаягийг ухаалаг лавламжийн аргаар тогтоож чадаагүй бол бичиг баримтыг хүлээн авагчийн хамгийн сүүлд мэдэгдэж байсан харьяа байгууллагын, байнгын оршин суугаа газрын болон шуудангийн хаягаар баталгаат захиа болон хүргэх оролдлогын тэмдэглэл үйлдэгдсэн бусад аргаар хүргэсэн байвал бичиг баримтыг хүлээн авсанд тооцно.

б/ Бичиг баримтыг хүргэсэн өдрийг уг бичиг баримтыг хүлээн авсан өдөрт тооцно.

2. Энэ зүйлийн заалт шүүхийн үйл ажиллагаанд хамаарахгүй.

4 дүгээр зүйл. Татгалзах эрхээсээ татгалзах

Талууд энэ хуулийн энэ заалтаас зайлсхийж болох тухай, эсвэл арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүйг мэдэж байгаа боловч арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үргэлжлэн оролцож, энэ талаар татгалзлаа нэн даруй мэдэгдээгүй, эсвэл энэ талаар тогтоосон хугацаанд татгалзлаа гаргаагүй бол татгалзах эрхээсээ татгалzsанд тооцно.

5 дугаар зүйл. Шүүхийн оролцох хэмжээ хязгаар

Энэ хуулинд зааснаас бусад тохиолдолд уг хуулиар зохицуулж буй асуудалд шүүх оролцохгүй.

6 дугаар зүйл. Шүүх болон бусад байгууллага арбитраас тодорхой эрх хэмжээгээ хэрэгжүүлэхэд нь үйлчлэх ба хяналт тавих

11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлэхэд энэхүү нэг маягийн хуулийг хүлээн зөвшөөрсөн алив улсын шүүх болон бусад эрх бүхий байгууллагууд энэ үүргийг биелүүлэхэд нь үйлчлэх, хяналт тавих талаар хуулиндаа заалт оруулбал зохино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
Арбитрын хэлэлцээр

Нэгдүгээр хувилбар

7 дугаар зүйл. Арбитрын хэлэлцээрийн хэлбэр ба тодорхойлолт */Энэ зүйлийг 2006 оны 39 дүгээр чуулганаар НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос нэмэлт оруулсан/*

1. “Арбитрын хэлэлцээр” нь талуудын хооронд ямар нэг эрхийн харилцаатай холбоотой үүссэн буюу үүсч болох тодорхой маргааныг арбитрт шилжүүлэх тухай гэрээний шинжтэй эсэхээс хамаарахгүй тохиролцсон тохиролцоо мөн.

2. Арбитрын хэлэлцээрийг бичгээр байгуулна.

3. Арбитрын хэлэлцээр эсвэл гэрээг амаар, үйлдлээр эсвэл бусад хэлбэрээр байгуулсаныг үл харгалзан арбитрын хэлэлцээрийн агуулгыг ямар нэгэн хэлбэрээр баталгаажуулсан бол хэлэлцээр бичгээр байгуулсанд тооцно.

4. Электрон холбоонд агуулагдсан мэдээлэлд нэвтэрч, цаашид иш татан хэрэглэх боломжтой бол арбитрын хэлэлцээр бичгээр байгуулсанд тооцно.

“Электрон холбоо” гэдэгт талуудын өгөгдөл мэдээлэллийн тусламжтайгаар харилцсан төрөл бүрийн харилцаа холбоог хэлнэ. “Өгөгдөл мэдээлэл” гэдэгт электрон, соронзон, гэрлийн болон бусад ижил төстэй арга хэлбэрээр гаргаж авсан, илгээсэн, хүлээн авсан эсхүл хадгалсан мэдээллийг хэлэх бөгөөд үүнд дараах мэдээлэл хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: электрон өгөгдөл солилцоо, электрон шуудан, телеграм, телекс болон гэрэл зургийн аргаар олшруулах.

5. Талуудын тохиролцсоныг аль нэг тал нотолж, нэхэмжлэлийн өргөдөл гаргасан, түүнд эсрэг тал татгалзсан хариу өгөөгүй зэргийг хэлэлцээр бичгээр байгуулсан тооцно.

6. Арбитрын хэлэлцээрийг агуулсан бичиг баримтын тухай гэрээнд дурдсан тохиолдолд гэрээ байгуулсан ба тухайн ишлэл гэрээний салшгүй хэсэг болох тухай заалт байгаа нөхцөлд арбитрын хэлэлцээр болно.

Хоёрдугаар хувилбар

7 дугаар зүйл. Арбитрын хэлэлцээрийн тодорхойлолт /Энэ зүйлийг 2006 оны 39 дүгээр чуулганаар НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос нэмэлт оруулсан/

“Арбитрын хэлэлцээр” нь талуудын хооронд ямар нэг эрхийн харилцаатай холбоотой үүссэн буюу үүсч болох тодорхой маргааныг арбитрт шилжүүлэх тухай гэрээний шинжтэй эсэхээс хамаарахгүй тохиролцсон тохиролцоо мөн.

8 дугаар зүйл. Арбитрын хэлэлцээр ба шүүхэд маргааны талаар нэхэмжлэл гаргах

1. Хэрэв талууд маргааны талаархи анхны өргөдөлдөө маргааныг арбитрт шилжүүлэхийг хүссэн бөгөөд арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус эсвэл гүйцэтгэх боломжгүй болсоноос бусад тохиолдолд бол шүүх нэхэмжлэлийг арбитрт шилжүүлнэ.

2. Шүүхэд харьяаллын асуудлыг шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа ч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэхэмжлэлийн дагуу арбитр хэрэг хянан хэлэлцэх ажилагаа явуулж арбитрын шийдвэр гаргаж болно.

9 дүгээр зүйл. Арбитрын хэлэлцээр ба шүүхээс арбитрын шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах нь

Арбитраас хэрэг хянан хэлэлцэхийн өмнө болон хэрэг хэлэлцэх явцад талууд арбитрын шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах тухай шүхэд хүсэлт гаргах болон шүүх ийм арга хэмжээ авах нь арбитрын хэлэлцээртэй ямар нэг байдлаар зөрчилдөхгүй.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
Арбитрын бүрэлдэхүүн**

10 дугаар зүйл. Арбитрчдын тоо

1. Талууд харилцан тохиролцож арбитрчдын тоог тогтооно.
2. Хэрэв талууд ийнхүү тогтоогоогүй бол 3 арбитрч томилно.

11 дүгээр зүйл. Арбитрчийг томилох

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол иргэний харьяллаас нь хамааруулан арбитрчаар томилохгүй байхыг хориглоно.
2. Талууд өөрсдийн үзэмжээр энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан журмыг баримтлан арбитрч буюу арбитрчдыг томилно.
3. Ийм хэлэлцээр байхгүй үед:
 - а/ 3 арбитрч оролцох бол тал тус бүр нэг арбитрчийг томилох ба томилогдсон 2 арбитрч гуравдахь арбитрчийг томилно. Хэрэв нэг тал нөгөө талаас арбитрч томилох тухай хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрчaa томилоогүй, эсвэл хоёр арбитрч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор гуравдагч арбитрчийг томилоогүй бол аль нэг талын хүсэлтээр энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан байгууллага буюу шүүх арбитрчийг томилно.
 - б/ Нэг арбитрч хэрэг шийдвэрлэх үед талууд арбитрчийг томилоогүй бол аль нэг талын хүсэлтээр энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан байгууллага буюу шүүх арбитрчийг томилно.
4. Хэрэв талуудын арбитрчийг томилохоор тохиролцсон журмын дагуу
 - а/ нэг тал ийм журмын дагуу үүргээ биелүүлээгүй,
 - б/ талууд болон 2 арбитрч ийм журмын дагуу тохиролцонд хүрч чадаагүй,
 - в/ гуравдагч байгууллага буюу иргэн ийм журмын дагуу үүргээ биелүүлээгүй бол аль нэг тал талуудын арбитрчийг томилохоор тохиролцсон журмаар арбитрчийг томилох өөр арга хэлбэрийг заагаагүй бол энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан шүүх болон бусад байгууллагад зайлшгүй арга хэмжээ авах талаар хүсэлт гаргах эрхтэй.
5. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан шүүх болон бусад байгууллагаас энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт дурдсан аль ч асуудлаар гаргасан шийдвэрт гомдол гаргах эрхгүй. Талууд тохиролцсоны дагуу шүүх болон бусад байгууллагаас арбитрчийг томилоходоо энэхүү тохиролцонд дурдсан арбитрч хэрэгт ямар нэг сонирхолгүй, хараат бус байх бүх шаардлагыг харгалзах ёстой. Хэрэв хэргийг дангаар шийдвэрлэх, эсвэл гуравдагч арбитрчийг томилох бол талуудын иргэншлээс өөр иргэншилтэй арбитрчийг томилохыг урьтал болгоно.

12 дугаар зүйл. Татгалзах үндэслэл

1. Хэрэв аль нэг хүнийг арбитрчаар томилохыг хүсвэл ийнхүү хүсэлт хүлээн авсан этгээд өөрийн хараат бус, хэрэгт ямар нэг сонирхолгүй байхад эргэлзэх нөхцөл байдлын талаар мэдэгдэх үүрэгтэй. Арбитрч талуудад энэ тухайгаа

мэдэгдээгүй бол томилогдоноосоо хойш болон хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль ч шатанд талуудад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

2. Зөвхөн талуудын тохиролцсон мэргэжлийг эзэмшээгүй, эсхүл түүний хараат бус, хэрэгт ямар нэг байдлаар сонирхолтой болох нь үндэслэлтэйгээр тогтоогдсон нөхцөлд арбитрийг татгалзана. Аль нэг тал өөрийн томилсон эсвэл томилоход оролцсон арбитрийг зөвхөн томилогдоных нь дараа илэрхий болсон үндэслэлээр татгалзаж болно.

13 дугаар зүйл. Татгалзах журам

1. Талууд өөрсдийн үзэмжээр энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан арбитрийг татгалзах журмыг тохирно.

2. Талууд арбитрийг татгалзан гаргах журмыг тохиролцоогүй бол 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал илэрсэн буюу арбитрын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн томилогдоноос хойш 15 хоногийн дотор арбитрт татгалзах тухайгаа бичгээр мэдэгдэнэ. Талууд татгалзал гаргасан боловч арбитрч өөрөө хүлээн зөвшөөрөөгүй, эсвэл нөгөө тал татгалзлыг хүлээн зөвшөөрөөгүй бол арбитрийг татгалзан гаргах асуудлыг арбитр шийдвэрлэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журам болон талуудын зөвшөөрсөн аливаа журмыг баримтлан арбитрч татгалзах тухай хүсэлтийг хүлээн аваагүй бол татгалзал гаргасан тал 30 хоногийн дотор шүүх болон 6 дугаар зүйлд заасан бусад байгууллагад шийдвэр гаргахыг хүсч болно. Энэ шийдвэрт ямар нэг байдлаар гомдол гаргахгүй. Татгалзлыг шийдвэрлэх явцад арбитр уг арбитрийг оролцуулан хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлэх ба арбитрын шийдвэр гаргаж болно.

14 дүгээр зүйл. Эс үйлдэл буюу үйлдэл хийх боломжгүй байдал

1. Арбитрч хууль зүйн дагуу болон бодитойгоор өөрийн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон буюу бусад шалтгаанаар ухаалаг биш удаан хугацаагаар үүргээ гүйцэтгээгүй, түүнчлэн өөрөө албан үүргээсээ татгалзсан, талууд түүнийг татгалзахаар тохиролцсон тохиолдолд түүний бүрэн эрх дуусгавар болно. Хэрэв эдгээр үндэслэлийн талаар маргаан гарвал аль нэг тал 6 дугаар зүйлд заасан байгууллага болон шүүхэд арбитрийн бүрэн эрхийг дуусгавар болгуулахаар хүсэлт гаргаж болно. Энэ шийдвэрт гомдол гаргаж болохгүй.

2. 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг ба энэ зүйлд заасан үндэслэлээр арбитрч өөрөө үүргээсээ татгалзсан буюу талууд бүрэн эрхийг нь дуусгавар болгохыг зөвшөөрсөн явдал арбитрч энэ зүйл болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль ч үндэслэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдохгүй.

15 дугаар зүйл. Шинэ арбитрч томилох

Хэрэв арбитрийн бүрэн эрх 13, 14 дүгээр зүйлд зааснаар дуусгавар болсон, арбитрч өөрөө ямар нэгэн шалтгаанаар арбитрч байхаас татгалзсан, эсвэл талуудын хэлэлцээр болон бусад үндэслэлээр арбитрийн бүрэн эрх

дуусгавар болсон бол шинэ арбитрчийг хуучин арбитрчийг томилсон журмын дагуу нөхөн томилно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **Арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ**

16 дугаар зүйл. Өөрийн эрх хэмжээнийхээ талаар тогтоол гаргах эрх

1. Арбитрын бүрэлдэхүүн өөрийн эрх хэмжээний талаар болон арбитрын хэлэлцээр байгаа эсэх, хүчинтэй эсэх талаар тогтоол гаргах эрхтэй. Энэ зорилгоор гэрээний бүрэлдэхүүн болох арбитрын хэлэлцээр нь гэрээний бусад нөхцөл хүчинтэй байгаа эсэхээс хамаарахгүйгээр хүчин төгөлдөр тооцогдоно. Арбитрын бүрэлдэхүүнээс гэрээг хүчин төгөлдөр бусад тооцсон шийдвэр гаргасан нь арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

2. Хариуцагч арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээний талаар нэхэмжлэлийн талаар татгалзал гаргахаас өмнө гомдол гаргаж болно. Талууд арбитрчийг томилох буюу түүнийг томилоход оролцсон нь арбитрын эрх хэмжээний талаар гомдол гаргахад саад болохгүй. Арбитрын бүрэлдэхүүн эрх хэмжээгээ хэтрүүлсэн гэж үзвэл талууд энэ тухай гомдлыг арбитраас хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль ч үед гаргаж болно. Арбитрын бүрэлдэхүүн ийнхүү гомдол гаргасан нь хожимдсон боловч ийнхүү хожимдуулсан явдал хүндэтгэн үзэх үндэслэлтэй гэж үзвэл гомдлыг аль ч үед хүлээн авч болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт гомдлын талаар арбитрын бүрэлдэхүүн тогтоол гаргах буюу хэрэг шийдвэрлэсэн шийдвэртээ зааж, арбитрын тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд болон 6 дугаар зүйлд заасан байгууллагад гомдол гаргаж болно. Эндээс гарсан шийдвэрт гомдол гаргах эрхгүй байна. Энэ хүсэлтийг шийдвэрлэх хүртэл арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлэх буюу арбитрын шийдвэр гаргаж болно.

ДӨРӨВИЙН “А” БҮЛЭГ.

Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ болон урьдчилсан тогтоол /Энэ бүлгийг 2006 оны 39 дүгээр чуулганаар НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос нэмэлт оруулсан/

1 дэх хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ

17 дугаар зүйл. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах талаархи арбитрын шүүхийн бүрэн эрх

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч болно.

2. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ гэдэгт шийдвэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэгдсэн аливаа нэгэн түр арга хэмжээг хэлэх бөгөөд үүгээр хэргийн эцсийн шийдвэр гаргахаас өмнө аль ч үе шатанд ч арбитрын бүрэлдэхүүн аль нэг талд дараах үүрэг даалгаврыг өгнө. Үүнд:

- а/ Маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа байдлаа хадгалах эсхүл сэргээх
- б/ Арбитрын ажиллагаанд саад учруулах буюу шууд хор хохирол, ялгаварлах байдал үүсгэж болох аливаа үйлдэл хийхээс зайлсхийх
- в/ Арбитрын шийдвэрийг хангахад хэрэглэгдэж болох хөрөнгийг хадгалах арга хэмжээ авах
- г/ Маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой, үнэн зөв нотлох баримтыг хадгалах.

17 дугаар зүйлийн “А” хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах нөхцөл

1. 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “а”, “б”, “в”-д заасан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг хүссэн тал нь арбитрын шүүхийн өмнө дараахи нөхцөлийг хангасан байна. Үүнд:

а/ Хэрэв тухайн арга хэмжээг аваагүй тохиолдолд хохирол арилгуулах тухай шийдвэрээр хохиролыг хангалттай барагдуулах боломжгүй, тухайн арга хэмжээг авснаар уг хохирлын хэмжээ нь хариуцагчид учрах хохирлын хэмжээнээс нилээд хэмжээгээр давсан бол

б/ Хүсэлт гаргагч талын нэхэмжлэлийн шаардлага хангагдах магадлал өндөр байгаа бол. Ийнхүү магадлалыг тогтоох нь арбитрын бүрэлдэхүүний цаашдын шийдвэр гаргах үзэмжид нөлөөлөхгүй.

2. 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “г”-д заасан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсгийн “а”, “б”-д заасан шаардлагыг арбитрын бүрэлдэхүүн тохиромжтой гэж үзсэн тохиолдолд л хамаарна.

2 дахь хэсэг. Урьдчилсан тогтоол

17 дугаар зүйлийн “Б” хэсэг. Урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл, түүнийг гаргах нөхцөл

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг тал нөгөө талдаа мэдэгдэлгүйгээр шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авахуулах тухай хүсэлтийг нөгөө талыг уг арга хэмжээний зорилтыг алдагдуулахгүй байхыг шаардсан урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдлийн хамт гаргаж болно.

2. Арбитрын бүрэлдэхүүн нь урьдчилсан тогтоолыг шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авахуулах тухай хүсэлтийг хариуцагчид урьдчилан мэдэгдсэнээр уг арга хэмжээний зорилтыг алдагдуулна гэж үзсэн тохиолдолд гаргаж болно.

3. 17 дугаар зүйлийн “А” хэсэгт заасан нөхцлүүд нь аливаа урьдчилсан тогтоолд хамаарах бөгөөд энэ тохиолдолд 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “а”-д зааснаар үнэлгээ хийгдэх хохиролын хэмжээ нь тухайн тогтоолыг гаргасан эсэхээс хамааран гарах өндөр магадлалтай хохирол байна.

17 дугаар зүйлийн “В” хэсэг. Урьдчилсан тогтоолын онцгой дэглэм

1. Урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдлийг арбитрын бүрэлдэхүүн нь шийдвэрлэсэн даруй талуудад шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний хүсэлт, урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл, эсхүл урьдчилсан тогтоол болон үүнтэй холбоотой аль нэг тал болон арбитрын бүрэлдэхүүний хооронд гарсан яриа хэлэлцээрийн агуулгыг дурдах зэрэг бүхий л харилцаа холбооны талаар мэдэгдэнэ.

2. Арбитрын бүрэлдэхүүн нь хариуцагч талд аль болох эрт өөрийн тайлбарыг гаргах боломжоор хангана.

3. Арбитрын бүрэлдэхүүн нь урьдчилсан тогтоолд гарах аливаа татгалзлыг нэн даруй шийдвэрлэнэ.

4. Урьдчилсан тогтоол нь арбитрын бүрэлдэхүүнээс уг тогтоолыг гаргасан өдрөөс хойш 20 хоногийн дотор хүчин төгөлдөр үйлчилнэ. Арбитрын бүрэлдэхүүн нь хариуцагчид мэдэгдсэн, өөрийн тайлбарыг гаргах боломжоор хангасны дараагаар урьдчилсан тогтоолыг баталсан эсвэл өөрчилсөн шийдвэрийг баталгаажуулах арга хэмжээ авч болно.

5. Урьдчилсан тогтоолыг талууд заавал биелүүлэх үүрэгтэй хэдий ч шүүхээс гүйцэтгэх ажиллагаа хийгдэхгүй. Урьдчилсан тогтоол нь арбитрын шийдвэр болохгүй.

3 дахь хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ болон урьдчилсан тогтоолд хамаарах журам

17 дугаар зүйлийн “Г” хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ, урьдчилсан тогтоолыг өөрчлөх, гүйцэтгэлийг түдгэлзүүлэх, зогсоох

Арбитрын бүрэлдэхүүн нь өөрийн санаачлагаар шийдвэрийн биелэлтийн хангах арга хэмжээ, урьдчилсан тогтоолыг аль нэг тал өргөдөл гаргаснаар, эсхүл онцгой тохиолдолд талуудад урьдчилтан мэдэгдэл хүргүүлснээр өөрчилж, гүйцэтгэлийг түдгэлзүүлж, зогсоож болно.

17 дугаар зүйлийн “Д” хэсэг. Гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгох

1. Арбитрын бүрэлдэхүүн нь шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авахыг хүссэн талыг уг арга хэмжээтэй холбоотойгоор зохих гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгож болно.

2. Арбитрын бүрэлдэхүүн нь урьдчилсан тогтоолыг гаргуулах тухай өргөдөл гаргасан талыг тохиромжгүй эсвэл шаардлагагүй гэж үзсэнээс бусад тохиолдолд зохих гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгож болно.

17 дугаар зүйлийн “Е” хэсэг. Талуудын мэдэгдэх үүрэг

1. Арбитрын бүрэлдэхүүн нь аль нэг талыг шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг хүсэх эсхүл олгох үндэслэл болсон хэргийн нөхцөл байдал эрс өөрчлөгдсөнийг нэн даруй мэдэгдэхийг шаардаж болно.

2. Урьдчилсан тогтоолыг гаргуулах тухай өргөдөл гаргасан тал нь арбитрын бүрэлдэхүүнд тогтоолыг гаргах эсхүл хэвээр үлдээх шийдвэрт ач холбогдолтой байж болох хэргийн бүхий л нөхцөл байдлыг мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ үүрэг нь хариуцагчийг өөрийн тайлбараа гаргах боломжоор хангагдах хуртэл үргэлжлэнэ. Үүний дараагаар энэ зүйлийн 1 дүгээр хэсэг үйлчилнэ.

17 дугаар зүйлийн “Ё” хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ, урьдчилсан тогтоолоос гарах зардал, хохирол

Хэрэв арбитрын бүрэлдэхүүн нь сүүлд тухайн нөхцөл байдалд шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ, урьдчилсан тогтоолыг гаргах ёсгүй байсан гэж тогтоосон бол ийнхүү арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан, урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан тал нь хариуцагч талд эдгээрээс үүдэн гарсан аливаа зардал, хохирлыг арилгах үүрэгтэй. Арбитрын бүрэлдэхүүн нь хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль ч үед зардал болон хохиролыг арилгуулах тухай шийдвэр гаргаж болно.

4 дэх хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

1. Арбитрын бүрэлдэхүүнээс авсан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг талууд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд арбитрын бүрэлдэхүүнээс өөрөөр заагаагүй 17 дугаар зүйлийн “З” хэсэгт зааснаар эрх бүхий шүүхэд өргөдөл гаргаснаар аль улсад авснаас үл хамаарч гүйцэтгэх ажиллагаа хийгдэнэ.

2. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг хүссэн, хүлээн зөвшөөрүүлсэн, биелүүлэхээр болсон тал нь шүүхэд тухайн арга хэмжээг өөрчлөгдсөн, түдгэлзүүлсэн, цуцлагдсан тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

3. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх хүсэлт гаргасан улсын шүүх хэрэв боломжтой гэж үзсэн, арбитрын бүрэлдэхүүнээс гүйцэтгэх арга хэмжээтэй холбоотой шийдвэр гаргаагүй, ийнхүү шийдвэр гаргах нь гуравдагч талуудын эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бол хүсэлт гаргаж буй талыг гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгож болно.

17 дугаар зүйлийн “З” хэсэг. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах үндэслэл³

1. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг зөвхөн дор дурдсан үндэслэлээр хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болно. Үүнд:

³ 17 дугаар зүйлийн “З” хэсэгт заасан нөхцлүүд нь шүүхээс шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах нөхцөл байдлын тоог хязгаарлах зорилтыг агуулсан. Хэрэв тухайн улс орон үүнээс бага тооны татгалзах нөхцөл байдлыг баталсан тохиолдолд загвар хуулийн нэг мөр болгох зарчмитай зөрчилдөхгүй.

а/ Хариуцагч талаас шийдвэр биелүүлэх ажиллагааг хүлээн зөвшөөрч явуулах эрх бүхий шүүхэд хүсэлт гаргаж, шүүх дараахи нөхцөл хангагдсан гэж үзсэн:

1/ Ийнхүү татгалзах нь 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “а”-гийн 1, 2, 3, 4-т заасан үндэслэлтэй нийцсэн.

2/ Арбитрын бүрэлдэхүүнээс шийдвэрийн биелүүлэлтийг хангах арга хэмжээтэй холбоотойгоор гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгосныг биелүүлээгүй.

3/ Арбитрын бүрэлдэхүүнээс шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг цуцалсан, түдгэлзүүлсэн, арбитрын шүүх болсон тухайн улсын шүүхээс шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг цуцлах, түдгэлзүүлэх бүрэн эрхтэй бөгөөд үүнийгээ хэрэгжүүлсэн, шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авсан хуулийн дагуу тус арга хэмжээг цуцлах, түдгэлзүүлэхээр заасан.

б/ Шүүх дараах байдлыг тогтоосон:

1/ Шүүхээс шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг өөрийн эрх мэдэл, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд нийцүүлэн биелүүлэх зорилготойгоор түүний үндсэн агуулгад өөрчлөлт оруулалгүйгээр уг арга хэмжээг дахин томъёолохоос бусад тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ нь шүүхийн бүрэн эрхэд нийцээгүй

2/ 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “б”-ийн 1, 2-т заасан үндэслэл тус бүр шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд үйлчилнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль нэг үндэслэлээр шүүхээс гаргасан шийдвэр нь гагцхүү шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд л хүчин төгөлдөр үйлчилнэ. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг хүлээн зөвшөөрч, биелүүлэх шүүх нь ийнхүү шийдвэр гаргахдаа шийдвэр биелүүлэх ажиллагааны үндсэн агуулгыг хянахгүй.

5 дахь хэсэг. Шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ

17 дугаар зүйлийн “И” хэсэг. Шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ

Шүүхээс арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагаатай нэгэн адил өөрийн улсын нутаг дэвсгэрт болж байгаа эсэхээс үл хамааран шүүхийн хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны дагуу шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авах бүрэн эрхтэй. Шүүхээс энэхүү эрх мэдлийг олон улсын арбитрын онцлогийг харгалзан үзсэнээр өөрийн хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны дагуу хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ
Арбитрт хэрэг хянан шийдвэрлэх

18 дугаар зүйл. Талуудын тэгш эрх

Арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ба аль ч тал өөрийн байр суурийг илэрхийлэх бүх боломжоор хангагдсан байна.

19 дүгээр зүйл. Арбитрт хэрэг хянан хэлэлцэх журам

1. Энэ хуульд заасан журмыг баримтлан талууд арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны журмыг тохиролцож болно.

2. Хэрэв талууд энэ талаар тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийг баримтлан өөрийн үзэмжээр хянан хэлэлцэх ажиллагааг явуулна. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлэх явдал арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд хамаарна.

20 дугаар зүйл. Арбитрын хэрэг хянан хэлэлцэх газар

1. Талууд тохиролцон арбитрын хэрэг хянан хэлэлцэх газрыг тогтооно. Хэрэв энэ талаар тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн хэргийн нөхцөл байдлыг харгалзан талуудад аль тохиромжтой газрыг сонгоно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийг үл харгалзан талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн арбитрчдын хооронд зөвлөлгөөн хийх, гэрч, шинжээч болон талуудыг сонсох, эд хөрөнгө болон баримт бичигт үзлэг хийхэд тохиромжтой газрыг сонгож болно.

21 дүгээр зүйл. Арбитрт хэрэг хянан хэлэлцэж эхлэх

Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол тодорхой маргааныг хянан хэлэлцэх ажиллагаа уг маргааныг арбитрт шилжүүлсэн тухай хүсэлтийг хариуцагч хүлээн авсан өдрөөс эхэлнэ.

22 дугаар зүйл. Хэрэг хянан хэлэлцэх хэл

1. Талууд арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг ямар хэлээр явуулах талаар тохиролцож болно. Хэрэв тохиролцоогүй бол түүнийг арбитрын бүрэлдэхүүн тогтооно. Талууд эсвэл арбитраас тогтоосон хэл нь өөрөөр заагаагүй бол талуудын өргөдөл, тайлбар бичих, хэрэг сонсох, арбитрын тогтоол, шийдвэр бусад мэдэгдэл гаргах бүхий л үйл ажиллагаанд хамаарна.

2. Арбитрын бүрэлдэхүүн талууд болон арбитраас тогтоосон хэлээр бичгийн бүх нотлох баримтыг орчуулахыг аль ч талаас шаардаж болно.

23 дугаар зүйл. Нэхэмжлэлийн өргөдөл ба хариуцагчийн татгалзал

1. Талуудын тохиролцсон буюу арбитрын тогтоосон хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлага, түүнийг нотлох баримтыг өөрийн шаардлагын агуулга, шийдвэрлэвэл зохих асуудлуудын хамт гаргаж өгөх, хариуцагч татгалзлаа үндэслэх нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Талууд арбитрын бүрэлдэхүүнд өргөдөл буюу татгалзлын хамт хэрэгт холбогдолтой гэж үзсэн бүх нотлох баримтыг гаргаж өгнө.

2. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй, арбитрын бүрэлдэхүүнээс өөрчлөх хүсэлтийг хожимдуулсан явдлыг харгалзан үзэж хүсэлтийг хангах боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд аль нэг тал арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль ч шатанд нэхэмжлэлийн шаардлага эсвэл татгалзлалын тайлбараа өөрчилж, нэмж болно.

24 дүгээр зүйл. Хэргийн бичгийн нотлох баримтаар буюу сонсгох журмаар хянан хэлэлцэх

1. Арбитрын бүрэлдэхүүн талуудын хэлэлцээрийг баримтлан хэргийг нотлох баримтыг уншин сонсгох замаар амаар хянаж хэлэлцэх эсвэл хэргийн материалд буй нотлох баримтыг үндэслэн хуралдаан явуулах асуудлыг шийдвэрлэнэ. Талууд хэргийг уншин сонсгохгүйгээр тохиролцсон боловч аль нэг тал уншин сонсгох хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль нэг шатанд уг хүсэлтийг хэрэгжүүлнэ.

2. Талуудад арбитрын бүрэлдэхүүн нотлох баримт уншин сонсгох ба бичиг баримт, эд хөрөнгө, бараа материалд үзлэг хийх, хурлын тухай мэдэгдэнэ.

3. Аль нэг тал арбитрын бүрэлдэхүүнд гаргасан өргөдөл, баримт бичиг болон бусад мэдээллийг нөгөө талд хүргүүлбэл зохино. Арбитрын бүрэлдэхүүнээс шийдвэр гаргахад үндэслэл болж болох шинжээчийн дүгнэлт, бусад нотлох баримтыг талуудад хүргүүлнэ.

25 дугаар зүйл. Нотлох баримт гаргаж өгөхгүй буюу талууд хуралд хүрэлцэн ирэхгүй байх

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр
а/ Нэхэмжлэгч 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийн өргөдлөө гаргаагүй бол арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг зогсоно.

б/ Хариуцагч 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар татгалзлаа гаргаагүй бол нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүйгээр хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

в/ Аль ч тал хэрэг хэлэлцэх ажиллагаанд оролцоогүй буюу нотлох баримтаа гаргахгүй бол арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлж, хэрэгт байгаа нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргаж болно.

26 дугаар зүйл. Арбитрын шүүх шинжээч томилох

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн

а/ арбитрын бүрэлдэхүүний тодорхойлсон асуудлаар дүгнэлт гаргуулахаар нэг буюу хэд хэдэн шинжээчийг томилж болно.

б/ шинжээчид хэрэгт холбогдолтой мэдээлэл өгөх, баримт бичиг, бараа материалд үзлэг хийх боломж олгохыг талуудаас шаардаж болно.

2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол талуудын хүсэлт буюу арбитрын бүрэлдэхүүнээс зайлшгүй гэж үзсэн тохиолдолд шинжээч дүгнэлтээ бичгээр эсвэл амаар гаргасны дараа талуудаас шинжээчид асуулт тавих боломж олгох,

маргаантай асуудлаар гэрч-шинжээчийн мэдүүлэг өгөх боломж олгох зорилгоор шинжээчийг хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд оролцуулна.

27 дугаар зүйл. Нотлох баримт гаргуулахад шүүх дэмжлэг үзүүлэх

Арбитрын бүрэлдэхүүн эсвэл түүний зөвшөөрлөөр талууд холбогдох улсын шүүхэд нотлох баримт гаргуулахад дэмжлэг үзүүлэхийг хүсч болно. Шүүх нотлох баримтыг өөрийн дүрэм эрх хэмжээнийхээ хүрээнд гаргуулж өгнө.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Арбитрын шийдвэр гаргах ба хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг зогсоох

28 дугаар зүйл. Маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх хэм хэмжээ

1. Арбитрын бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэхдээ талуудын тохиролцон сонгож авсан эрх зүйн хэм хэмжээг баримтлана. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг улсын эрх зүйн систем буюу хууль тогтоомж гэснийг материалын эрх зүйд шууд хамааруулах ба харин зөрчилдөөнтэй хэм хэмжээнд хамааруулахгүй.

2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн хэрэглэж болно гэж үзсэн зөрчилдөөнтэй хэм хэмжээний дагуу тодорхойлсон эрх зүйг хэрэглэнэ.

3. Зөвхөн талууд шууд эрх олгосон тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн нөхөрсөг зохицуулагчийн үүргийг гүйцэтгэнэ.

4. Хэргийг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан гэрээ болон тухайн хэлцлийн талаар тогтсон худалдааны заншлын хэм хэмжээг баримтлана.

29 дүгээр зүйл. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргах

Арбитрын хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнд нэгээс илүү арбитрч оролцож байгаа үед талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн шийдвэрээ олонхийн саналаар гаргана. Талууд болон бусад арбитрчид эрх олгосон бол хурал даргалагч арбитрч хэрэг хянан хэлэлцэх журмыг тогтоож болно.

30 дугаар зүйл. Эвлэрэх хэлэлцээр

1. Хэрэв арбитрын хэрэг хянан хэлэлцэх явцад талууд эвлэрсэн бол арбитр хэрэг хэлэлцэх ажиллагааг зогсоож, талуудын хүсэлтээр буюу тэднийг татгалзаагүй бол эвлэрсэн нөхцлийг тэмдэглэж шийдвэр гаргана.

2. Талууд эвлэрсэн тухай арбитрын шийдвэр 31 дүгээр зүйлд заасан журмын шаардлагыг хангасан байвал зохино. Энэ шийдвэр арбитрын бусад шийдвэрийн нэг адил бөгөөд заавал биелэгдэх хүчинтэй.

31 дүгээр зүйл. Арбитрын шийдвэрийн агуулга, хэлбэр

1. Арбитрын шийдвэрийг бичгээр гаргах бөгөөд хэрэг шийдвэрлэсэн арбитрчид гарын үсэг зурна. Хэрэг хянан шийдвэрлэхэд нэгээс илүү арбитрч

оролцсон бол арбитрчдын олонхи гарын үсэг зурсан байхад хангалттай. Ингэхдээ зарим арбитрчийн гарын үсгээ зураагүй шалтгааныг дурдвал зохино.

2. Талууд хууль зүйн үндэслэл заах шаардлагагүй гэж тохиролцсон, эсвэл 30 дугаар зүйлд зааснаар талууд эвлэрснээс бусад тохиолдолд арбитрын шийдвэрт түүнийг гаргах болсон үндэслэлийг тодорхой заана.

3. Арбитрын шийдвэрт 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсноор арбитрын шийдвэр гаргасан газар, хугацааг заана. Шийдвэрийг энэ газар гаргасанд тооцно.

4. Арбитрын шийдвэр гарсны дараа энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар арбитрчдын гарын үсэгтэй шийдвэрийг талуудад хүргүүлнэ.

32 дугаар зүйл. Хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг дуусгавар болгох

1. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмыг хангасан арбитрын шийдвэр буюу тогтоол гарснаар арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа дуусгавар болно.

2. Арбитр дараах тохиолдолд хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг дуусгавар болгох тухай тогтоол гаргана:

а/ Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан үед хариуцагч хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг дуусгавар болгооос татгалзаагүй буюу хариуцагчийн маргааныг эцэслэн шийдвэрлэх сонирхлыг арбитр хүлээж аваагүй.

б/ Талууд хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг дуусгавар болгооор тохиролцсон.

в/ Арбитр хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлэхийг нь ямар нэг шалтгаанаар шаардлагагүй буюу боломжгүй гэж үзсэн.

3. Арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа дуусгавар болсноор 33, 34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан журамд харшлаагүй бол арбитрын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болно.

33 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийг тайлбарлах ба засвар оруулах, нэмэлт шийдвэр гаргах

1. Хэрэв талууд өөр хугацаа тогтоогоогүй бол шийдвэр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор:

а/ аль нэг тал нөгөө талдаа мэдэгдэн арбитрын шийдвэрт гарсан тооцооны буюу техникийн, түүнтэй төсөөтэй бусад алдааг засуулахаар хүсэлт гаргаж болно.

б/ талууд тохиролцсон бол аль нэг тал нөгөө талдаа мэдэгдэн арбитрын шийдвэрийн аль нэг хэсэг буюу зүйлийг тайлбарлуулахаар арбитрын шүүхэд хүсэлт гаргаж болно. Арбитр хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн бол түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зохих засвар хийх буюу тайлбар өгнө. Энэ тайлбар арбитрын шийдвэрийн бүрэлдэхүүн хэсэг болно.

2. Арбитр шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор өөрийн санаачлагаар энэ зүйлийн 1 дэх хэсгийн “а”-д заасан алдааг залруулж болно.

3. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг тал нөгөө талд мэдэгдэн арбитрын шийдвэр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитраас хэрэг хянан

хэлэлцэх ажиллагааны үед нэхэмжилсэн ямар нэг шаардлагын талаар шийдвэрт тусгаагүй бол энэ талаар нэмэлт шийдвэр гаргуулахыг хүсэж болно. Арбитр хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн бол 60 хоногийн дотор нэмэлт шийдвэр гаргана.

4. Арбитр гарсан алдааг засах, тайлбарлах болон энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар залруулах, тайлбарлах буюу нэмэлт шийдвэр гаргах хугацааг сунгаж болно.

5. 31 дүгээр зүйлд заасан журам нь арбитрын шийдвэрийг залруулах, тайлбарлах буюу нэмэлт шийдвэр гаргах үед хэрэглэгдэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ **Арбитрын шийдвэрт гомдол гаргах**

34 дүгээр зүйл. Арбитрын шийдвэрт гомдол гаргах өргөдөл

1. Шүүхэд арбитрын шийдвэрт зөвхөн энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан журмын дагуу хүчингүй болгуулахаар өргөдөл гаргаж болно.

2. Арбитрын шийдвэрийг 6 дугаар зүйлд заасан журмаар шүүх зөвхөн дараах тохиолдолд хүчингүй болгоно. Үүнд:

а/ Өргөдөл гаргасан тал дараах үндэслэлийн нотлох баримт гаргасан:

1/ 7 дугаар зүйлд зааснаар арбитрын хэлэлцээр байгуулсан тал аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсвэл арбитрын хэлэлцээр нь талуудын гэрээгээр тохиролцсон улсын хууль буюу ийм тохиролцоогүй бол тухайн улсын хуулиар хүчин төгөлдөр бус

2/ Арбитрч томилох, арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны тухай мэдэгдээгүй эсхүл бусад шалтгаанаар өөрийн тайлбарыг гаргаж чадаагүй

3/ Арбитрын хэлэлцээрт тусгагдаагүй эсвэл арбитрын хэлэлцээрээс гадуурхи асуудлаар тогтоол гаргасан.

4/ Арбитрын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилох болон хэрэг шийдвэрлэх журам талуудын тохиролцсоноос өөрөөр тогтоогдсон. Харин талуудын тохиролцоо нь энэ хуулийн талуудын татгалзах эрхгүй аливаа журамтай зөрчилдсөн буюу энэ хуулийн аливш журмыг зөрчсөн бол энэ заалт хамаarahгүй

б/ Шүүх дараах байдлыг тогтоосон:

1/ Тухайн улсын хуулиар маргааны зүйл нь арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны зүйл биш

2/ Арбитрын шийдвэр тухайн улсын нийтлэг журамд нийцээгүй.

3. Талууд шийдвэр хүлээн авснаас хойш 3 сар өнгөрсөн бол арбитрын шийдвэрт гомдол гаргах эрхгүй. Хэрэв хүсэлтийг 33 дугаар зүйлийн дагуу гаргасан бол арбитрын бүрэлдэхүүн хүсэлтийг шийдвэрлэнээс хойш 3 сар өнгөрсөн бол арбитрын шийдвэрт гомдол гаргах эрхгүй.

4. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан үед хэрэв шүүх боломжтой гэж үзсэн эсвэл аль нэг тал хүссэн бол арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг сэргээн явуулах боломж олгох, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах арга хэмжээ авахаар арбитр санал гаргасан бол шүүх шийдвэр гаргахаар тогтоосон хугацааг түдгэлзүүлж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ
Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

35 дугаар зүйл. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

1. Арбитрын шийдвэр аль улсад гарснаас үл хамаарч заавал биелэгдэх бөгөөд 36 дугаар зүйл болон энэ зүйлд зааснаар эрх бүхий шүүхэд бичгээр өргөдөл гаргаснаар гүйцэтгэх ажиллагаа хийгдэнэ.

2. Талууд арбитрын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа явуулах тухай өргөдөл гаргахдаа арбитрын шийдвэрийн эх хувь буюу баталгаатай хуулбарыг хавсаргана. Арбитрын шийдвэр нь тухайн улсын албан ёсны хэлээс өөр хэлээр гарсан бол шүүх талуудыг эдгээр баримт бичгийн орчуулгыг гаргуулахыг шаардаж болно⁴. /Энэ заалтыг 2006 оны 39 дүгээр чуулганаар НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссоос нэмэлт оруулсан/

36 дугаар зүйл. Шийдвэр биелүүлэх ажиллагааг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах үндэслэл

1. Аль улсад гарснаас үл хамаарч арбитрын шийдвэр биелүүлэх ажиллагааг хүлээн зөвшөөрөхөөс дор дурдсан үндэслэлээр татгалзаж болно. Үүнд:

а/ Хариуцагч талаас шийдвэр биелүүлэх ажиллагааг хүлээн зөвшөөрч явуулах эрх бүхий шүүхэд дор дурдсан нотлох баримтыг гаргасан:

1/ 7 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрт оролцогч аль нэг тал эрхийн чадамжгүй, энэ хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгож авсан улсын хуулиар буюу ийм заалтгүй бол шийдвэр гаргасан улсын хуулиар хүчин төгөлдөр бус

2/ Арбитрч томилох тухай болон арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны тухай албан ёсоор мэдэгдээгүй буюу бусад шалтгаанаар хариуцагч тайлбар гаргаж чадаагүй

3/ Арбитрч хэлэлцээрт тусгагдаагүй эсвэл уг хэлэлцээрээс өөр асуудлаар гарсан маргааныг шийдвэрлэсэн

4/ Арбитрын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн болон хэрэг шийдвэрлэх журам талуудын тохиролцсоныг зөрчсөн. Хэрэв энэ талаар тохиролцоогүй бол арбитрын байгаа улсын хуулийг зөрчсөн

5/ Шийдвэр гарсан улсын хуулиар тухайн шийдвэрийг шүүхээс хүчингүй болгосон, гүйцэтгэлийг түдгэлзүүлсэн зэргээр арбитрын шийдвэр эцсийн шийдвэр болж чадаагүй

б/ Шүүх дараах байдлыг тогтоосон:

1/ Тухайн улсын хуулиар маргаж буй зүйл нь арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны зүйл болохгүй

2/ Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх нь тухайн улсын нийтлэг журмыг зөрчсөн.

⁴ Эдгээр нөхцөл хамгийн хатуу болзлыг тавьсан болно. Хэрэв тухайн улс орон үүнээс хөнгөн нөхцөл тавьж байгаа тохиолдолд загвар хуулийн нэг мөр болгох зарчимтай зөрчилдөхгүй.

2. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох буюу татгалзах шийдвэрийг энэ хуулийн 1 дүгээр зүйлийн “а” хэсгийн 5-д дурдсан шүүх гаргасан бол шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлбэл зохих шүүх хэрэв боломжтой гэж үзвэл шийдвэр гаргахыг түр хойшлуулах, хүлээн зөвшөөрөх, биелүүлэхийг хүссэн талын өргөдөлд үндэслэн нөгөө талыг зохих гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгож болно.